



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 546

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол-Ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид ашиглахад эдийн засгийн хувьд ашиггүй болсон, 82,500,000.00 (наян хоёр сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 48,308,229.99 (дөчин найман сая гурван зуун найман мянга хоёр зуун хорин есөн төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Монгол-Ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Билэгсайханд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу тус үйлдвэрийн газарт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Б.ГАВАА



0002581



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн
ХТХ дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛ-УС" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арал, хөдөлгүүрийн дугаар	Ашиглаг-тад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Тоёота Ландкрузер-200, 06-05 УНУ, суудлын-5, арал- JTMHV09J45013256	2010.11.10	70 000	82 500 000.00	48,308,229.99	34,191,770.01	-	35,000,000.00
	НИЙТ ДҮН	-	-	82,500,000.00 (наян хоёр сая таван зуун мянган)	48,308,229.99 (дөчин найман сая гурван зуун найман мянга хоёр зуун хорин есөн төгрөг ерэн есөн мөнгө)	34,191,770.01 (гучин дөрвөн сая нэг зуун ерэн нэгэн мянга долоон зуун далан төгрөг нэг мөнгө)	-	35,000,000.00 (гучин таван сая)